



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн өргөн
чөлөө 3, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442273

Цахим шуудан: info@bayankhongor.gov.mn

Цахим хаяг: www.bayankhongor.gov.mn

2022.07.06

№ 21317

танай _____-ны № _____-т

Г

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАРТ

Г

Иргэдээс төрийн захиргааны байгууллага,
албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл,
гомдлын шийдвэрлэлтийн 2022 оны 2 дугаар
улирлын тайлан мэдээг хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудаастай.

ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

615221683

ИРГЭДЭЭС БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2022 оны 07 дугаар сарын 05

Номгон

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн хувиар
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шилжүүлсэн	Хугацаа болоогүй	
1	Засаг даргын Тамгын газар	211	177	28		6	97.1 %
2	Хэлтэс агентлаг	7560	7346	7		207	97.2%
3	Сумын ЗДТГ	2120	1750	42		328	84.5%
Дүн		9891	9273	77		541	94.5%

**ИРГЭДЭЭС БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ ХЭЛБЭРЭЭР**

2022 оны 07 дугаар сарын 05

Номгон

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Үүнээс					
			Бичгээр	11-11 төв болон 7044001 дугаараар	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан	Бусад
1	Засаг даргын Тамгын газар	211	171	40				
2	Хэлтэс агентлаг	7560	2831	3	1069	2568	1089	
3	Сумын ЗДТГ	2120	1947	1	44	73	38	17
Дүн		9891	4949	44	1113	2641	1127	17

_____ оОо _____

**ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН
АГУУЛГА ХУВЬ**

2022 оны 04 дүгээр сарын 05

Номгон

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал Тоо нийт өргөдөл, гомдлын эзлэх хувь
1	Баянхонгор	<p align="center">Нийт 9891 өргөдлөөс</p> <p align="center">1.Хүсэлт- 9827 (99.3%) 2.Санал- 22 (0.2%) 3.Гомдол-42 (0.2%)</p> <p>Ажил хүссэн- 309 (3.1%) Тусламж дэмжлэг хүссэн- 1862 (18.8%) Газрын асуудлаар- 342 (3.4%) Гэр хүссэн- 29 (0.2%) Нийгмийн даатгалын асуудлаар- 162 (1.6%) Нийгмийн халамжийн асуудлаар- 3516 (35.5%) Иргэний бүртгэлтэй холбоотой асуудлаар-151 (1.5%) Худалдаа үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл хүссэн- 219 (2.2%) Бусад асуудлаар-3301 (33.3%)</p>

_____оОо_____

**ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН
ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ,
ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 07 дугаар сарын 05

Номгон

Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, Нутгийн захиргааны байгууллагууд нь иргэдээс санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/259 дүгээр захирамжаар батлагдсан “Аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, тэдний санал, хүсэлтийг бодлого шийдвэртээ тусгаж ажиллах зарчмыг баримтлан ажиллалаа.

Аймгийн хэмжээнд төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн нийт 9891 санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авснаас аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт 211 санал, хүсэлт, өргөдөл, гомдол, Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагт 7560, сумдын Засаг даргын Тамгын газарт 2120 санал, хүсэлт, өргөдөл, гомдол ирсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт бичгээр 211 өргөдөл ирснээс 177 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж 28 өргөдөл гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлсэн.

Тайлангийн хугацаанд Засгийн газрын 1111 төвөөс нийт 37 санал, гомдол ирүүлснийг холбогдох хэлтсийн дарга, албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлүүлж, иргэнд хариуг утсаар болон албан тоотоор мэдэгдэж ажиллаа. Хүлээгдэж байгаа 23 гомдол байна. 2022 оны 05 сараас 06 дугаар сарын хооронд 1111 төвд ирэх гомдлын тоо эрс нэмэгдсэн.

Аймгийн Засаг дарга 7 хоног бүрийн Пүрэв гарагт иргэдийг хүлээн авч иргэдийн санал хүсэлтийг сонсож байна. Энэ оны эхний хагас жилд 5 удаагийн уулзалтаар 113 иргэнтэй аймгийн Засаг дарга уулзаж иргэдийн санал, хүсэлт тулгамдаж байгаа асуудлын талаар ярилцаж холбогдох албан тушаалтанд шилжүүлэн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлүүлж ажилласан.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам, “E-Mongolia” академийн хамтарсан баг 2022 оны 05 дугаар сарын 02-08-ны өдрүүдэд ажиллаж, нутгийн захиргааны 12

байгууллагын 31 төрлийн үйлчилгээг "E-Mongolia" системд нэвтрүүлсэн. Тус системээс 1264 төрлийн лавлагааг иргэд цахимаар авах боломж бүрдсэн ба аймгийн хэмжээнд 4500 иргэнд лавлагаа мэдээлэл гарган өгч, үйлчилгээтэй холбоотой заавар, зөвлөмж бүхий постер, видео шторк, бусад мэдээллийг фейсбүүк дэх аймгийн зарын групп, пейж хуудас болон орон нутгийн мэдээ мэдээллийн хэрэгслээр түгээн ажилласан байна.

"Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль" 2022 оны 05 дугаар сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Операторын системээс иргэн бүр хурууны хээгээр лавлагаа авах боломжгүй болж, зөвхөн цахим тоон гарын үсэг авсан иргэд болон өөрийн нэр дээр бүртгэлтэй утасны дугаар бүхий иргэд лавлагаа мэдээллээ авах зохицуулалттай болсон. Тиймээс тухайн хууль хэрэгжиж эхэлсэн 05 дугаар сараас "E-Mongolia" системд иргэдийг бүртгэж, лавлагаа гаргах үйлчилгээ улам бүр эрчимжиж байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв нь хагас жилийн байдлаар иргэн аж ахуйн нэгж байгууллагад төрийн үйлчилгээг нэг цэгээс түргэн шуурхай, нээлттэй үзүүлсэн Үүнд: E-hutuch.mn цахим хуудасны талаар боршур бэлтгэн үйлчлүүлсэн иргэдэд тарааж мэдээлэл өгсөн мөн E mongolia цахим хуудаснаас 225, Хур системээс 2392 иргэнд лавлагаа гаргаж үйлчилсэн байна. Мөн 5 төрийн байгууллагын 180 гаруй төрлийн үйлчилгээг 23614 иргэнд үйлчилсэн байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд 5 байгууллагын 198 төрлийн төрийн үйлчилгээг иргэдэд тасралтгүй үзүүлж байна. Энэ оны хагас жилийн байдлаар Хөдөлмөр халамжийн асуудлаар 31023 иргэн, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн асуудлаар 1272 иргэн, газрын асуудлаар 2360 иргэн, Хууль зүйн туслалцаа авахаар 194 иргэн, Нотариатын үйлчилгээг 1280 иргэн тус тус үзүүлсэн байна. 2022 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 36129 төрийн үйлчилгээг иргэн аж ахуйн нэгж байгууллагад үзүүлсэн.

Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөс үйлчилгээ авч байгаа 196 иргэнээс төрийн албан хаагчдын харилцаа хандлага, үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгаа авахад судалгаанд оролцсон иргэдийн 73 хувь нь албан хаагчдын харилцаа хандлагыг "сайн", 27 хувь нь дунд зэрэг гэж хариулжээ.